



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар *АБС*

Хэрлэн сум

Эд хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 73 дугаар тогтоол, 2022 оны 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын 8 238 700 төгрөгийн балансын үнэтэй, 1 765 435 төгрөг 68 мөн өний хуримтлагдсан элэгдэлтэй, 6 473 264 төгрөг 32 мөнгөний үлдэх өртөгтэй худалдах барилга байгууламжийг хавсралтаар баталсугай.

2. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Г.Лхагвахатан	Орон нутгийн өмчийн газрын дарга
Хөтлөгч:	С.Сосорбарам	Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн
Тэмдэглэл хөтлөгч:	Л.Отгончимэг	Орон нутгийн өмчийн газрын хуулийн зөвлөх

3. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2022 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 10:00 цагт Баянхутаг сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай.

4. Эд хөрөнгийг худалдах ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Г.Лхагвахатан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010287

Аймгийн Засаг даргын 2022 оны
 02 дүгээр сарын 15 өдрийн 183...
 дугаар захирамжийн хавсралт

ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн огноо	Ашиглалт ад орсон огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Сэргээн босгосон зардал	Худалдах үнийн санал		
										байгууллагын санал	ОНӨГ-ын санал	Хурлын шийдвэр
1	Баянхутаг сум ЗДТГазар	Зүүн конторын барилга	-	1969.05.01	1	8,238,700.00	1,765,435.68	6,473,264.32	0.00	2,000,000.00	6,480,000.00	2,000,000.00
Нийт дүн					1	8,238,700.00	1,765,435.68	6,473,264.32	0.00	2,000,000.00	6,480,000.00	2,000,000.00